



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 75

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 26,900,000 /хорин зургаан сая есөн зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 71-38 ДУА улсын дугаартай УАЗ-31542-012 маркийн автомашины худалдах доод үнийг 2,500,000 /хоёр сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн), Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (П.Очирхүү) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны нэгдүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн  
15 дугаар тогтоолын хавсралт



Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн худалдах  
тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Тээврийн хэрэгслийн нэр	Улсын бүртгэлийн		Үйлд вэрл эсэн он	Ашиг лалт ад орсо н он	Санхүүгийн тайланд тусгагдсан дүн	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Гурвансайхан сум ЭМТөв	УАЗ-469	ДУА	7138	2013	2013	26,900,000	26,900,000	0.00	2,500,000
Нийт							<b>26,900,000</b> /хорин зургаан сая есөн зуун мянга/ төгрөг	<b>26,900,000</b> /хорин зургаан сая есөн зуун мянга/ төгрөг	-	<b>2,500,000</b> /хоёр сая таван зуун мянга/ төгрөг